

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, АРГА зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4 Байгууллагын зорилго үйл ажиллагаа, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	8
2.9.1 Мөнгөн хөрөнгө	8
2.9.2 Авлага.....	8
2.9.3 Өр төлбөр	9
2.9.4 Засгийн газрын хувь оролцоо.....	9
2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.12. Шилэн дансны мэдээлэл	10
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3. Менежментийн захидал.....	11
3.1 Балансын данстай холбоотой асуудал.....	11
3.2 Зардлын данстай холбоотой асуудал.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаатай холбоотой асуудал.....	11
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	14
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	16
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18
6.Төлбөрийн акт.....	22-23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХХҮХ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
ХУД	Хан-Уул дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Т.БАДРАХБАЯР
ТАНАА

2020.03.25 № 01/932
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Нийгмийн халамжийн сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Нийгмийн халамжийн сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайланг материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийгмийн халамжийн сангийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Y:\10.10.10.20\Bichig_Kherag\Yamsan_Bichig\2020\0325SAGB.Docx

001051071

Үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.ТЭНГИС

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Нийгмийн халамжийн сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Т.Бадрахбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох авлага барагдуулах, төсвөөс үр ашиггүй зардал гаргахгүй байх, төв сангийн санхүүгийн бие даасан санхүүгийн тайланг гаргаж байх талаар 3 зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Нийгмийн халамжийн сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийгмийн халамжийн сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 09-ний өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын аудитор С.Бат-Эрдэнэ гүйцэтгэв.

Нийгмийн халамжийн сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/373 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе САГ-2020/09/СТА-ЗГТС

шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Нийгмийн халамжийн сан нь эрүүл мэндийн доройтолтой , гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн халамж, асрамж дутагдалтай, бие даан , эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүнд иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох , тусгайлсан үйлчилгээ үзүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлсон байна.

Үйл ажиллагааны чиглэл:

Нийгмийн халамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлд зааснаар Нийгмийн халамжийн үйл ажиллагаа нь дараах төрөлтэй байна. Үүнд:

- Нийгмийн халамжийн тэтгэвэр
- Нийгмийн халамжийн тэтгэмж
- Нийгмийн халамжийн үйлчилгээ
- Нийгмийн хөгжлийн үйлчилгээ

Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд дараах нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлж байна.

- Ахмад настны нийгмийн халамжийн үйлчилгээ
- Зорилтот бүлэгт чиглэсэн тэтгэвэр, тэтгэмж
- Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаа
- Хүүхдийн мөнгө
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн халамж
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ
- Зорилтот өрхийн хөгжлийг хангах төсөл хөтөлбөр
- Нийгмийн ажлын арга зүй
- Хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа
- Төрөлжсөн асрамж

Нийгмийн халамжийн үйл ажиллагаа нь Нийгмийн халамжийн тухай хууль, Ахмад настны тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль, Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл хөнгөлөлт олгох тухай хууль, Эх олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль болон салбарын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн актаар зохицуулагдаж байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нийгмийн халамжийн сангийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Нийгмийн халамжийн сангийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Хяналт, мониторингийн газар Нийслэлийн Багануур, Хан-Уул, Сүхбаатар, Баянгол дүүргийн ХХҮХ, Архангай, Өвөрхангай, Ховд, Увс, Орхон, Баянхонгор, Завхан аймгийн ХХҮГ-ын 2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж халамжийн үйл ажиллагааны чиглэлээр 10 төрлийн зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийн биелэлтийг газар, хэлтэс бүрээр үнэлж, Багануур, Ховд аймагт “С”, Хан-Уул, Увс аймагт “D”, Баянгол, Сүхбаатар, Өвөрхангай аймаг, Архангай аймаг, Завхан аймагт “F” үнэлгээ өгсөн бол Баянхонгор, Орхон аймгийн ХХҮГ-ын зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлээгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Нийгмийн халамжийн сангийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг Нийгмийн халамжийн сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 684,434.7 сая төгрөгийн 1 хувь буюу 6,844.3 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг дахин тооцоолоогүй болно.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн Халамжийн сангийн нийт 30 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 29 байгууллага аудитад хамрагдсан, 1 байгууллагад итгэл үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан 29 харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

Нийгмийн халамжийн сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 22,497.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 20,890.4 сая төгрөгийн 12 алдааг аудитын явцад залруулж, 1,149.5 сая төгрөгийн 6 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 7.0 сая төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 450.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 34 зөвлөмжийг хүргүүллээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн зардлыг 1,739.6 сая төгрөгөөр илүү нэгтгэсэн байна.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

1. Архангай, Булган, Өвөрхангай, Увс аймгийн Халамжийн дэд сангаас 2019 оны 12-р сарын 31-нд төсвийн зарцуулагдаагүй 276.3 сая төгрөгийн үлдэгдэл төвлөрүүлснийг санхүүгийн тайланд замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдлээр тайлагнасан ба Нийгмийн халамжийн сангийн харилцах дансанд 2020 оны 1 дүгээр сарын 2-нд орлого орсныг 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар төсөвт төвлөрүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйл.Төсвийн жил дамжин хэрэгжих арга хэмжээний зохицуулалт, 43.5 дахь "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй" заасантай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Нийгмийн халамжийн сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар арилжааны банканд 3,024.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй, 2,119.8 сая төгрөгийн олгогдоогүй тэтгэвэр, тэтгэмжийн өглөгтэй тайлагнаж, 905.0 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдэлтэй байна. Үүний 451.5 сая төгрөг нь 2018 оны насны хишиг, цалинтай ээж хөтөлбөрийн олгогдоогүй мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, 32.6 сая төгрөгийн хүүгийн орлого, бусад 420.9 сая төгрөгийн үлдэгдэл нь илүү болон давхар олгогдсон тэтгэвэр, тэтгэмжийн буцаалтын орлогын үлдэгдэл эзэлж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйл: Төсвийн жилийн 7.7 -д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", 43 дугаар зүйл.Төсвийн жил дамжин хэрэгжих арга хэмжээний зохицуулалт, 43.5 дахь "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй", Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох журам"-ын 4.4-т "Тэтгэвэр, тэтгэмжийг тухайн онд авч чадаагүй бол дараагийн санхүүгийн жилд нөхөн олгоно.Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 1 жилээс дээш хугацаагаар тэтгэвэр, тэтгэмжээ аваагүй нөхцөлд нөхөн олгохгүй" заасантай тус тус нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үүнээс хүүгийн орлогын 32.6 сая төгрөг болон Дорнод аймгийн Төрийн аудитын газраас төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар тогтоосон 3.5 сая төгрөгийн төлбөрийн актын дүнг хасаж, 868.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Төвлөрүүлсэн захирагчид 28.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн алдаа, зөрчил

Харьяа байгууллагын нийгмийн халамжийн сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 19,584.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 19,150.8 сая төгрөгийн 11 алдааг аудитын явцад залруулж, 4.4 сая төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 6.9 сая төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 422.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 31 зөвлөмжийг хүргүүлээ.

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 19,150.8 сая төгрөгийн залруулга хийлээ. Тухайлбал:

- Сүхбаатар дүүргийн ХХҮХ санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангуудын өмнөх оны дүн аудит хийгдсэн тайлангийн дүнгээс 18,897.5 сая төгрөгөөр зөрүүтэй,
- Өмнөговь аймгийн ХХҮГ санхүүгийн байдлын тайланд өмнөх үеийн үр дүн болон тайлант үеийн дүнг 151.2 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- Орхон аймаг мөнгөн тайланд зардлыг 57.1 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн.

Залруулагдаагүй 434.0 сая төгрөгийн алдаа, зөрчлийг аудитын тайлангийн хавсралтын зөрчлийн нэгтгэлийн хүснэгтэд тусгав.

2.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.9.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 858.7 сая, эцсийн үлдэгдэл 3,301.1 сая төгрөг болж, 2,442.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	-	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	858.7	3,024.8	2,166.1	91.6
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	276.3	276.3	8.4
Хадгаламж				
Дүн	858.7	3,301.1	2,442.4	100.0

Эх сурвалж: Нийгмийн халамжийн сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 3,024.8 сая төгрөг арилжааны банкны дансанд байршиж байгаа, 276.3 сая төгрөг замд яваа мөнгөн хөрөнгө байна.

Архангай, Булган, Өвөрхангай, Увс аймгийн ХХҮГ-аас 2019 оны 12-р сарын 31-нд төв санд шилжүүлсэн санхүүжилтийн үлдэгдэл тайлант хугацаанд ороогүйгээс замд яваа мөнгөн хөрөнгөөр бүртгэсэн байна.

2.9.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 0.1 сая, эцсийн үлдэгдэл 94.0 сая төгрөг болж, 93.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад авлага	0.1	94.0	94.0
Зээлийн авлага			
Дүн	0.1	94.0	94.0

Эх сурвалж: Нийгмийн халамжийн сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын дансны үлдэгдэл 93.9 сая төгрөг байгаа нь :

- Орхон аймгийн ХХҮГ болон ХУД, СХД, БГД-ийн ХХҮХ-ийн Капитал банканд байршиж байсан тэтгэвэр, тэтгэмжийн 77.1 сая төгрөгийн дансны үлдэгдлийг тус банкны үйл ажиллагаа татан буугдсантай холбоотойгоор авлагаар бүртгэсэн,
- Архангай, Ховд, Дархан-Уул аймгийн ХХҮГ болон БЗД-ийн ХХҮХ-ийн иргэдэд илүү болон давхардуулан олгосон 9.7 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийн авлага,
- Дархан-Уул аймгийн ХХҮГ нь амьжиргаа дэмжих мөнгөн тусламжийн орлогыг улсын төсвийн сангаас санхүүжүүлсэн 7.2 сая төгрөгийн дүнгээр орон нутгийн төсвөөс авах авлага үүссэн байна

2.9.3 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 3,131.3 сая, эцсийн үлдэгдэл 2,119.8 сая төгрөг болж, 1,011.5 сая төгрөгөөр буурсан/ байна.

Хүснэгт № 3 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Олгогдоогүй тэтгэвэр, тэтгэмжийн өглөг	3,131.3	2,119.8	-1,011.5	100
Нийт дүн	3,131.3	2,119.8	-1,011.5	100

Эх сурвалж: Нийгмийн халамжийн сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн дансанд 8 аймаг, 9 дүүргийн халамжийн сангийн 14 төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн олгогдоогүй 2,119.8 сая төгрөгийн өглөг бүртгэгдсэн байна.

2.9.4 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл (2,272.5) сая, эцсийн үлдэгдэл 1,275.3 сая төгрөг болж, 3,547.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 4. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Хуримтлагдсан үр дүн Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	(2,272.5)	1,275.3	3,547.8	100
Дүн	(2,272.5)	1,275.3	3,547.8	100

Эх сурвалж: Нийгмийн халамжийн сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ЗГ-ын 2019 оны 471 дүгээр тогтоолын дагуу Баян-Өлгий аймгийн орон нутгийн халамжийн сангийн 2018 оны 1,739.6 сая төгрөгийн өр төлбөрийг Нийгмийн халамжийн сангаас төлж барагдуулсан дүнгээр өмнөх үеийн үр дүнг бууруулж, 2018 оны олгогдоогүй тэтгэвэр, тэтгэмжийн мөнгөний үлдэгдлээс иргэдийн аваагүй 451.5 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийн дүнгээр өмнөх үеийн үр дүнг нэмэгдүүлж бүртгэсэн байна.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 688,203.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас бараа үйлчилгээний зардалд 2,011.9 сая төгрөгийг, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардалд 686,191.2 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 688,203.1 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 688,203.1 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 668,294.0 сая төгрөг буюу 97.1 хувьтай байгаа нь ядуу өрхийн тэтгэмжийн зардалд 9,223.7 сая төгрөг төсөвлөгдсөн боловч уг тэтгэмжийг зохицуулсан журам нь батлагдаагүйгээс тэтгэмж олгогдоогүй, мөн гүйцэтгэлээр хүүхдийн мөнгөн тэтгэмжийн зардал 1,608.2 сая, нийгмийн халамжийн бусад хөнгөлөлт тэтгэмжийн зардал 1,603.1 сая, халамжийн тэтгэвэр 1,248.8 сая, жирэмсэн эхийн тэтгэмж 2,252.7 сая,

амьжиргааг дэмжих мөнгөн тусламж 668.6 сая, нөхцөлт мөнгөн тэтгэмж 737.7 сая, насны хишгийн тэтгэвэр 525.9 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэнээс шалтгаалсан байна.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Нийгмийн халамжийн сангийн төсвийн төлөвлөлт, хуваарилалт үндэслэлтэй эсэхийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ. Мөн ХХҮЕГ-ын Хяналт, мониторингийн газраас Нийгмийн халамжийн төв сангийн үйл ажиллагаанд сүүлийн 3 жилийн хугацаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Нийгмийн халамжийн сан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 20 төрлийн 133 мэдээллийг хуулийн хугацаанд, 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө тайланг байршуулаагүй байна.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилт 2019 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Нийгмийн халамжийн сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй дүгнэлт

Залруулагдаагүй 1,607.4 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 6,844.3 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

Нийгмийн халамжийн сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Нийгмийн халамжийн сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Архангай, Ховд, Дархан-Уул аймгийн ХХҮГ, Баянзүрх дүүргийн ХХҮХ-үүд иргэдэд илүү олгосон болон арилжааны банкны алдаатай үйл ажиллагаанаас давхардуулан олгосноос 9.6 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс санхүүжих амьжиргаа дэмжих мөнгөн тусламжийн 7.2 сая төгрөгийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлснээс нийт 16.7 сая төгрөгийн авлага үүссэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл.Төсвийн зарчмыг хэрэгжүүлэх. 6.4.8.-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заасантай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Холбогдох хууль, тогтоомж, журам, заавар зөрчсөн байх, Санхүүгийн тайланд он дамжсан авлага үүсэх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Давхардуулан олгосон болон орон нутгийн төсвөөс авах авлагыг 2020 оны 2 дугаар улиралд барагдуулж, Нийгмийн халамжийн төв сангийн дансанд төвлөрүүлэх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан бөгөөд төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

3.2 Зардлын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

